



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 11/17

Мандалговь

Хурдан морины бүсийн уралдааны
2017 оны хуваарийг тогтоох тухай

Монгол Улсын Үндэсний баяр наадмын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-8.5 дах заалт, аймгийн нарны хүлэг уяачдын холбооноос ирүүлсэн саналыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Мандалын хурд" хаврын бүсийн уралдааныг 2017 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Эрдэнэдалай суманд дээд гурван нас, эрлийз дунд нас, "Дэлгэрхангай уулын тахилга" баруун бүсийн уралдааныг 2017 оны 06 дугаар сарын 09-ны өдөр Дэлгэрхангай суманд их нас, соёолон, Зүүн бүсийн бага гурван нас, эрлийз бага насны уралдааныг Дэлгэрцогт суманд 2017 оны 07 дугаар сарын 22-нд, Хулд суманд зохион байгуулагдах "Түмэн адууны баяр" төвийн бүсийн уралдааныг 2017 оны 07 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд азарга, их нас, соёолон, хязаалан, шүдлэн, даага, эрлийз бага нас уралдуулахаар хуваарийг товлон баталсугай.

Хоёр. Хурдан морины уралдааныг тогтоосон хугацаанд хууль дүрмийн дагуу зохион байгуулалтын өндөр түвшинд, уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр явуулахыг холбогдох Сумдын Засаг дарга, аймгийн Нарны хүлэг уяачдын холбоо, аймгийн МСЗУХ-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

010000129

